ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны жилийн эцсийн байдлаар

№	Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Хариуцах нэгж	Хувь
1	1.1.	ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдийн шаардлагад нийцсэн ИНҮТ-ийн ерөнхий зааврууд ыг боловсруулах, ИНҮТ-ийн ерөнхий зааврууд ыг ИНЕГ-ын НААХЗА-д хүргүүлж, хянуулан, батлуулах.	Ерөнхий зааврууд ыг боловсруулсан эсэх ИНЕГ-ын НААХЗА-д хүргүүлж, хянуулж, батлуулсан эсэх	II улирал	ИНҮТ-ийн харьяа ХНАА нь ИНД-171, НХҮА нь ИНД-172, НМҮА нь ИНД-175, НБЖШНА нь ИНД-173, БУОУНБ нь ИНД-139 дүрмүүдээр тусдаа гэрчилгээжсэн. ИНЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/398 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан. ИНҮТ-ийн харьяа албад ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдээр тусдаа гэрчилгээжсэн үйл ажиллагаа яӨвуулж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдийн шаардлагад нийцсэн ИНҮТ-ийн ерөнхий зааврууд ыг боловсруулсан байна. ИНҮТ-ийн ерөнхий зааврууд ыг ИНЕГ-ын НААХЗА-аар хянуулж, ИНҮТ-ийн даргаар батлуулсан байна.	ИНҮТ ИНД-ээр гэрчилгээжих ажлын хүрээнд нэгдсэн эрсдэлийн үнэлгээ болон шилжих ажлын төлөвлөгөөг боловсруулан ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175 дүрмүүдийн хүрээнд боловсруулагдах үйл ажиллагааны ерөнхий зааврын төслүүдийг 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр, ИНД-139 дүрмийн шаардлагад нийцсэн үйл ажиллагааны ерөнхий зааврын төслийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр боловсруулж ИНЕГ-ын ИНҮТ-д 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. ИНД-171 дүрмийн хүрээнд ерөнхий зааврыг 2024.02.29 өдөр боловсруулсан бөгөөд гэрчилгээний хугацаа дуусахтай уялдуулан шинэчлэн боловсруулж, 2024.09.11-ны өдөр 09-1/1042 тоот албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн. ИНД-172 дүрмийн хүрээнд “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ерөнхий заавар”-т нэмэлт өөрчлөлт оруулсныг 2024 оны 06 дугаар сарын 19-нд НААХЗА-аас хянан, баталсан. “Нислэгийн	АБЧУГ ҮҮГ	100%

							хөдөлгөөний үйлчилгээний ерөнхий журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсныг 2024 оны 06 дугаар сарын 27-нд НААХЗА-аас хянан, баталсан. Хүчин төгөлдөр батлагдсан заавар, журмын дагуу холбогдох ажлын байрны үйл ажиллагааны зааврууд нэмэлт өөрчлөлт оруулж, үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.		
2	1.2.	ИНҮТ ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдээр гэрчилгээжих.	ИНҮТ дүрмүүдээр гэрчилгээжсэн эсэх	II улирал		**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдээр гэрчилгээжсэн байна.	1. ИНД-173 дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэрчилгээг 2024.03.26-ны өдөр авсан. 2. ИНД-172 дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэрчилгээг 2024.04.09-ний өдөр авсан. 3. ИНД-139 дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэрчилгээг 2024.04.02-ны өдөр авсан. 4. ИНД-175 дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэрчилгээг 2024.04.12-ны өдөр авсан. 5. ИНД-171 дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэрчилгээг 2024.04.12-ны өдөр авсан.	АБЧУГ ҮҮГ	100%
3	2.1.	/ИНЕГ 4.1/ Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг эрчимжүүлэх,	Шүүхийн шийдвэр гаргуулсан эсэх Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	I-IV улирал	Шүүхийн шийдвэрийг хүлээж байна. А блокийн барилгын ажил 90 хувьтай байна	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Шүүхийн шийдвэр гаргуулсан байна. **II-III улиралд:** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ	Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажил 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зогссон. БГД-ийн шүүх дээр маргаантай шүүх хурал 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүртэл дахин хойшилсон.	АЖЛЫН ХЭСЭГ ХОЗА	30%

		ашиглалтад оруулах.			Б блокийн барилгын ажил 30 хувьтай байна.	байгуулан, барилгын ажлыг эхлүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **IV улиралд:** Барилга угсралтын ажлыг дуусгаж, байнгын ашиглалтад хүлээн авсан байна.	ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2024.04.18-ны өдрийн хурлаас "Үүрэг трейд" ХХК-тай байгуулсан гэрээг цуцлах тухай шийдвэр гарч, гэрээ цуцлах тухай мэдэгдлийг "Үүрэг трейд" ХХК болон Баянгол дүүргийн шүүхэд хүргүүлсэн. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гэрээг цуцлуулахтай холбогдуулан тус барилгыг хүлээн авч акт үйлдэх, цаашид барилгын ажлыг дуусгахад шаардлагатай төсөв, төлөвлөгөөг гаргаж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/251 дугаартай тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн төлөвлөгөөг гаргахад шүүхийн шийдвэрийг харгалзан үзэхээр хүлээгдэж байна. Барилгын ажлын тухайд: А блок 90 хувьтай. Д блок 90 хувьтай. В блок 70 хувьтай. Б блок 30 хувьтай. Г блок 20 хувьтай. Дэд өртөө, гадна цахилгаан 46 хувьтай хэвээрээ. Ажлын хэсгээс барилгын ажлын талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ЗТЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна. ИНУТ-ийн даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн		

							үйлдвэрлэлийн шуурхай 13 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд ИНҮТ-ийн алба салбаруудын инженерүүдээс бүрдсэн “Иргэний нисэхийн ерөнхий газрын Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажил”-д холбогдуулан Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж буй “Үүрэгтрейд” ХХК-д холбогдох иргэний хэрэгт тус шүүхээс томилогдсон шинжээчийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 48/2 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын шинжээчийн дүгнэлт”-ийн “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын хийж гүйцэтгэсэн ажлын төсөв”-т туссан ажлын гүйцэтгэлийг хүлээн авч акт үйлдэх, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/251 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгөх дэд ажлын хэсгийг ИНҮТ-ийн даргын 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс барилгын ажлын тоо хэмжээнд нарийвчилсан тулгалт хийж, хийгдээгүй болон нэмэлтээр		

							төсөв тооцуулах шаардлагатай ажлын тоо хэмжээний жагсаалтыг баталгаажуулан тайлангийн хамт 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 09-1/1150 тоот албан бичгээр ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн газарт хүргүүлсэн. ИНЕГ дээр байгуулагдсан Ажлын хэсэг уг барилгыг бүрэн ашиглалтад оруулах үлдэгдэл ажлын төсвийг 2025.01.01–ний өдрөөс мөрдөгдөж эхлэх барилгын ажлын цалингийн шинэчилсэн тарифаар шинэчлэн тооцуулж, магадлалаар оруулах ажлыг гүйцэтгүүлэх гэрээг хийх ажлын зохион байгуулж байна.		
4	2.2.	/ИНЕГ 4.3/ Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын “Сайншанд” хоёр дахь төв байгуулах ТЭЗҮ хийлгэх.	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэх ТЭЗҮ-г хүргүүлсэн эсэх	I-III улирал	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хоёр дахь төв байгуулах ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар батлагдсан. ИНҮТ өөрийн орлогоос санхүүжих 2024 оны төсөвт 1.5 тэрбум төгрөг тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** ТЭЗҮ боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. **II улиралд:** Шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд**: Боловсруулсан ТЭЗҮ-ийг ИНЕГ-т хүргүүлсэн байна.	ТЭЗҮ боловсруулах төсвийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Гадны байгууллагуудаас хөрөнгө оруулалт татах зорилгоор 2024 оны 01 дүгээр 26 өдөр (IATA), 02 дугаар сарын 22-ны өдөр Сингапур улсын ST Engineering компанитай тус тус уулзалт зохион байгуулж хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийг танилцуулсан. 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Япон улсын “Холбоо, агаарын навигацийн системийн холбоо”-ны төлөөлөгчидтэй уулзаж, тус төслийн ТЭЗҮ-г боловсруулахад шаардлагатай хөрөнгө оруулалт болон тус төслийг дэмжих боломжтой эсэх талаар зөвшилцөн,	ҮҮГ	30%

							цаашид хамтран ажиллах боломжийг судлахаар тохиролцсон. Сайншанд хоёр дахь төв байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулан ИНЕГ-ын 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд саналаа тусгасан боловч хасагдсан. Улмаар 2024 оны төсвийн тодотголд дахин оруулсан боловч тодотгол хийгдээгүй. Иймд 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд 1,5 тэрбум төгрөгийг батлуулахаар саналаа оруулсан. /2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 01/1585 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.		
5	2.3.	/ИНЕГ 4.5/ Аэродром, ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчилж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн сургалтын танхим байгуулах.	Ажлын даалгавар баталж, тендер зарласан эсэх Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэх Захиалагчийн хяналт тавьсан эсэх Олон улсын стандарт шаардлагад нийцсэн	I-IV улирал	Ажлын даалгаврыг боловсруулсан. 2023 онд тендер сонгон шалгаруулалт зарласан боловч тендер амжилтгүй болсон.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Ажлын даалгавар баталж, тендер зарласан байна. **II Улиралд:** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Захиалагчийн хяналт тавьсан байна. **IV улиралд:** Олон улсын стандарт шаардлагад	Иргэний нисэхийн үндэсний төвийн Техник, технологийн зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар НХҮА-аас ирүүлсэн “Аэродром, ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчлэх” техникийн тодорхойлолтыг хянан баталсан. Улмаар ИНЕГ-ын даргын 2024.04.24-ний өдрийн А/234 дүгээр тушаалаар тендерийг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Төвийн даргаас “Техникийн тодорхойлолтыг дахин боловсруулах” чиглэл өгсөний дагуу Техник технологийн зөвлөлөөс 2024 оны 06 дугаар сарын 17, 2024 оны 8 дугаар	ҮҮГ	30%

			сургалтын танхим байгуулсан эсэх			нийцсэн сургалтын танхимтай болсон байна.	сарын 14-ны өдрүүдэд техникийн тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлсэн. "Аэродром, ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчлэх" тендерийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зарласан. 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нээсэн. Үнэлэх ажил хийгдэж байна.		
6	2.4.	/ИНЕГ 4.8/ "Монгол Улсын агаарын зайд чөлөөт агаарын зайг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-нд тусгасан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн гүйцэтгэх.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	"Монгол Улсын агаарын зайд чөлөөт агаарын зайг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 2023.11.20-ны өдөр ИНЕГ-ын даргаар батлуулсан.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	"Монгол Улсын агаарын зайд чөлөөт агаарын зайг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-нд Иргэний нисэхийн үндэсний төвийн хариуцсан болон хамтран гүйцэтгэх 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2024 онд 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр байна. Хэрэгжилт 57.1%-тай. 0%-1 арга хэмжээ 30%-тай 3 арга хэмжээ 90%-тай 1 арга хэмжээ 100%-тай 1 арга хэмжээ	УУГ	50%
7	2.5.	/ИНЕГ 4.9/ Үзүүлэлтэд тулгуурласан навигаци	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-III улирал	"Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн төлөвлөгөөг	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:**	ЗТХ сайдын "Агаарын зам шинэчлэн батлах тухай" А/10 дугаартай тушаал нь 2022 оны 1 дүгээр сарын 19-нд	УУГ	70%

		(PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд тусгасан 2024 онд хэрэгжүүлэх ажлуудыг гүйцэтгэх.			2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр баталсан. "Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх судалгааны ажлыг хийж байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар: III улиралд**: Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	батлагдсан, ИНЕГ-ын даргын "Агаарын замын зохион байгуулалт батлах тухай" А/208 дугаартай тушаал 2022 оны 7 дугаар сарын 25-нд батлагдсан бөгөөд нислэгийн үйл ажиллагаанд 2022 оны 10 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн ашиглаж эхэлсэн. 2023 оны 5 дугаар сард Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу RNAV-5 үзүүлэлттэй агаарын замуудаас RNP-2 үзүүлэлтэд шилжүүлэхээр Монгол улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчдээс тохирох тоноглолын шаардлага хангаж буй талаар, холбоо болон ажиглалтын хамрах хүрээний судалгаануудыг тус тус хийсэн. Эдгээр судалгаа нь агаарын замуудыг нислэгт ашигласнаас хойш хэтэрхий богино хугацаа/5сар/-нд хийгдсэн тул жил орчим ашигласны дараа дахин судалгаа хийх нь илүү үр дүнтэй гэсэн шийдвэрийг АННББЗГ-аас шийдвэрлэсэн. Иймээс 2023 онд хийгдэх ажлууд уг судалгаануудаас шалтгаалан хийгдэх боломжгүй болсон тул Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд өөрчлөлт, оруулж оруулж		

							ИНЕГ-ын БХХ-ийн дарга Ч.Одгэрэлээр 2024.05.31-ний өдөр шинэчлэн батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу 2024 онд хийж гүйцэтгэх 11 ажил байгаагаас 8 ажил нь 100% хэрэгжилттэй үлдсэн 3 ажлын хэрэгжүүлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд нийт төлөвлөгөөний хэрэгжилт 72%-тай байна.		
8	2.6.	/ИНЕГ 4.10/ CRV сүлжээ ашиглан холбогдох техникийн туршилт явуулах санал солилцож, төлөвлөгөө боловсруулан станцуудыг холбох техникийн туршилт хийх.	Төлөвлөгөөг баталсан эсэх Туршилт хийсэн эсэх	II-III улирал	Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас дэвшүүлэн тавьсан бүс нутгийн нэгдсэн CRV сүлжээнд холбогдон PCCW компанитай гэрээ байгуулсан.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Төлөвлөгөөг баталсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Туршилт хийсэн байна.	ХНАА-ны даргын 2023.06.06-ны өдрийн А/42 дугаартай тушаалаар CRV сүлжээний замчлагч CE router (NID) төхөөрөмжийг суурилуулж, холболт туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ази дахь CRV сүлжээний үйлчилгээ үзүүлэх Хонгконг улсад төвтэй PCCW компанитай тус сүлжээний үйлчилгээ авах гэрээг ИНЕГ нь тус компанитай 2022.10.05-ны өдөр байгуулсан. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн А/127 дугаар тушаалын дагуу AMHS системийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор Нисэхийн мэдээ зохицуулах систем (AMHS)-ийг БНХАУ-ын AMHS систем-тэй холбож турших ажлыг ИНҮТ-ийн даргын А/143, А/165 дугаар тушаалуудаар гүйцэтгэж байгаа бөгөөд туршилт шалгалтын ажлыг CRV сүлжээг	ҮҮГ	100%

							ашиглан гүйцэтгэсэн. Иймд CRV сүлжээг ашиглан AMHS мессеж солилцож эхэлсэн.		
9	2.7.	/ИНЕГ 4.11/ Шинэ техник, технологи, инновацын бүтээлд шалгарсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх.	Санхүүжилтийг шийдвэрлэсэн эсэх Хэрэгжүүлсэн төслийн тоо	I-IV улирал	Шинэ техник, технологи, инновацын бүтээлүүд шалгарсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд**: Төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэж, эхлүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Иргэний нисэхийн салбарт 2-оос доошгүй инновацын төсөл хэрэгжүүлсэн байна.	ИНЕГ-ыг даргын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/227 дугаар тушаалаар "Уралдаан зохион байгуулах, сонгон шалгаруулалтын комисс байгуулах тухай" тушаал баталсан. - Иргэний нисэхийн салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ойн арга хэмжээг угтан "Шинэ санаа, шилдэг төслийн инновацын уралдаан"-ыг Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжүүдийн нийт ажилтнуудын дунд 2024 оны 04 дүгээр сарын 22-ноос 05 дугаар сарын 17-ны өдрийн хооронд зарласан. Уралдаанд ирүүлсэн төслийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр нэгтгэн дүгнэж, байр эзлүүлсэн. Үүнд: - 1-р байранд Нисэхийн сургалтын төвийн "ICAO-ийн хэлний ур чадварын TEAC шалгалтын Монгол улсад нутагшуулах төсөл" шалгарсан. Уг төслийн хүрээнд шалгалтын хураамжаар орлого бүрдүүлэн, ИНҮТ-ийн дансанд орлого бүрдэж байна. 2024.11.20-ны өдрийн байдлаар 22,5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. 2024 онд төлөвлөсөн орлого бүрдүүлэлт 86%-тай байна. -2-р байранд Нисэхийн холбоо, навигаци ажиглалтын албаны	ҮҮГ	100%

							"Агаарын навигацийн алслагдсан байгууламжуудад хяналтын систем нэвтрүүлэх төсөл" шалгарсан. Уг төслийн хүрээнд тоног төхөөрөмжийн худалдан авалт, туршилт шалгалтын ажил хийгдэж дууссан. ИНҮТ-ийн даргын 2024 оны А/169 дүгээр тушаалын дагуу алсын хяналтын системийг суурилуулж, холбох ажлыг 2024.09.04-2024.09.06-ны өдрүүдэд гүйцэтгэн хяналтын системийг нэвтрүүлсэн. Төслийн хэрэгжилт 100%-тай байна. - 3-р байранд Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын Аэродром гэрэл суултын албаны "Ховд аймаг дахь "Ховд" нисэх буудлын цахилгааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах техникийн шийдэл, эдийн засгийн үр ашгийн тооцоо судалгааны төсөл" шалгарсан. Уг төслийн хүрээнд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг ИНҮТ-ийн техник, комиссын зөвлөлөөр хэлэлцэж, 2025 оны төсөвт өөрийн орлогын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.		
10	2.8.	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй холын /HF/ холбоог ОУИНБ-ын	Судалгаа хийсэн эсэх Батлагдсан төлөвлөгөөний тоо	II-III улирал	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй холын /HF/ холбооны станцын ашиглалтын	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд**: Судалгаа хийсэн байна.	Олон улсын агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын SATVOICE, SATCOM системийн ашиглалтын анхан шатны судалгааг хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны үр дүнг ИНҮТ-	ҮҮГ	30%

		зөвлөмж, шаардлагад нийцсэн хиймэл дагуулд суурилсан /VOICE and DATA/ холбоонд шилжүүлэх нөхцөл шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, ерөнхий төлөвлөлтийг боловсруулах, батлуулах.			хугацаа 2024 онд дуусаж байна. Хиймэл дагуулд суурилсан SATVOICE, SATCOM -ын анхдагч судалгааны ажлыг хийж байна.	**Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** **1**	ийн даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.		
11	2.9.	Автомат хамааралтай ажиглалтын системийн (ADS-B) газрын станцыг өргөтгөх. /2 газар /	Ажлын даалгавар баталж, тендер зарласан эсэх Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэх Гэрээ байгуулж, өргөтгөх ажлыг эхлүүлсэн эсэх Станцыг өргөтгөсөн эсэх	I-IV улирал	-	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Ажлын даалгавар баталж, тендер зарласан байна. **II Улиралд:** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж, өргөтгөх ажлыг эхлүүлсэн байна. **IV улиралд:**	Автомат хамааралтай ажиглалтын системийн (ADS-B) газрын станц 2 ширхэг /Хэнтий, Хөвсгөл/-ийг нийлүүлэх техникийн тодорхойлолтыг боловсруулан, тендерийг зохион байгуулах үнэлгээний хороо 2024.02.21-ний өдөр байгуулагдсан. Тендерт 4 компани материал ирүүлсэн бөгөөд "Тридум-Эсекьюрити" ХХК шалгарч 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр ИНЕГ/ХО/20240101022, ИНЕГ/20240102022 дугаартай гэрээ байгуулан 2025.03.03-ны өдөр хүлээн авч ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна.	ҮҮГ ХОЗА	50%

						Автомат хамааралтай ажиглалтын системийн газрын станцыг өргөтгөсөн байна.			
12	2.10.	Бүсийн нислэгийн хөдөлгөөний Бээжин ACC удирдлагын төв хооронд AMHS системийн холболтыг хийж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх.	Системийн холболт хийсэн эсэх Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн эсэх	III-IV улирал	ОХУ-ын бүсийн төвтэй AMHS системийг амжилттай хэрэгжүүлсэн. БНХАУ-ын Бээжин бүсийн төвтэй 2023 оны 9 сард уулзалт хийсэн. 2024 оны 7 сар хүртэл түр хойшлуулах, дахин санал солилцож шийдвэрлэхээр болсон.	**Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Системийн холболт хийсэн байна. **IV улиралд:** Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн Нисэхийн мэдээ зохицуулах систем (AMHS)-ийг БНХАУ-ын AMHS системтэй холбож турших ажлыг ИНҮТ-ийн даргын А/143, А/165 дугаар тушаалуудаар гүйцэтгэж байна.	ҮҮГ	50%
13	2.11.	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат системийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэр эрэлхийлэх, техникийн тодорхойлолтыг шинэчлэх.	Санхүүжилтийн эх үүсвэр судалсан эсэх Техникийн тодорхойлолтыг шинэчилсэн эсэх	I-IV улирал	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын Aircon2100 автомат систем нь 2023 онд тасралтгүй 24 цаг 15 жилийн турш ашиглагдаж байна. Тус системийг шинэчлэх хэрэгцээ шаардлага чухлаар тавигдаж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд**: Санхүүжилтийн эх үүсвэр судалж, төвийн даргад танилцуулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Техникийн тодорхойлолтыг шинэчилсэн байна.	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат системийг шинэчлэхээр 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа өгсөн. Техникийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Мөн Франц улсын Монгол дахь элчин сайд болон тус улсын Thales компанийн төлөөлөгчнар уулзаж, автоматжуулалтын системийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжийн талаар хэлэлцсэн. 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр Thales компанийн мэргэжилтнүүд ирж автоматжуулалтын системийн талаар танилцуулга хийсэн.	ҮҮГ	70%

14	2.12.	Чөлөөт агаарын зай (FRA) хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинэ бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн автоматжуулсан системтэй уялдуулан техник технологийн судалгааг хийх.	Судалгаа хийсэн эсэх	II-III улирал	Үзүүлэлтэд тулгуурласан навигацийг хэрэгжүүлж байгаа.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Судалгааны явц 70%-д хүрсэн байна. **III улиралд:** Судалгаа хийсэн байна. Үр дүнг ИНҮТ-ийн даргын зөвлөлд танилцуулсан байна.	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат системийн техникийн тодорхойлолт шинэчлэгдсэнтэй холдогдуулан сансарт суурилсан навигацийн техник технологийн судалгааг 2 төрлөөр хийж байна. Судалгааны ажлыг танилцуулахаар бэлтгэж байна.	ҮҮГ	50%
15	2.13.	ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвөөс дэвшүүлсэн GRF үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой ОУИНБ-ын холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтүүдийг судлан, хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах.	Судалгаа хийсэн эсэх Батлагдсан төлөвлөгөөний тоо Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Аэродромын инженерүүд GRF -ын сургалтад хамрагдсан ба ХБЗ-ны гадаргуугийн нөхцөл байдлын мэдээллийг форматын дагуу үнэлж мэдээлдэг. Үүний дагуу ICAO PANS-AIM 10066-н 2р өөрчлөлтөд орсноор 2021 оноос шинэ SNOWTAM форматыг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. APANPIRG/32, APANPIRG/33 хурлуудын зөвлөмжүүдийн дагуу “ХБЗ-ийн нөхцөл байдлын	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд**: Судалгаа хийсэн байна. **II улиралд**: 1 **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	GRF-ын хэрэгжилтийг хангах, батлах чиглэлээр ICAO-ын стандарт, зөвлөмж, журам (Annex 3, 6, 11, 14, 15, PANS 4444, 9981, 10066, Circular 355)-ууд болон GRF-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой ICAO-ын Ази/Номхон далайн бүсийн хурлуудын материал болон шийдвэрийг хэрэгжүүлсэн байдлыг судалсан. Судалгааны дагуу 3 арга хэмжээ бүхий “GRF үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө” гарган, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний дагуу хөөрч буух зурвасын нөхцөлийн үнэлгээ хийх, мэдээлэх зохицуулалтыг 2024 оны 11 сарын 14-ний өдрийн AIP AMDT 08/24 бүтээгдэхүүнээр хэвлэн нийтэлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна.	ҮҮГ	100%

					тайланг гаргаж, SNOWTAM шинэ форматыг гаргах журмыг үндэсний AIP-д нийтлэх ёстой." гэсний дагуу МУ-ын AIP-ын AD 1.2.2-д нийтлэх шаардлагатай байна.				
16	2.14.	Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үндэсний дадлага, сургуулилтыг зохион байгуулах.	Бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлуулсан эсэх Төлөвлөгөө ний хэрэгжилт, хувиар Арга хэмжээг зохион байгуулсан эсэх	I-III улирал	-	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд**: Бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлуулна. **II улиралд**: Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна. **II-III улиралд**: Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна. Арга хэмжээг зохион байгуулсан байна.	Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үндэсний дадлага, сургуулилтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албатай хамтран боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан. ИНҮТ-ийн 2024 оны санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй уялдуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв, зардлыг шийдвэрлэх шаардлага үүссэн. ИНҮТ-ийн 2025 оны урсгал зардлын төлөвлөгөөнд шаардлагатай төсвийг тусгуулахаар ажиллаж байна.	ҮҮГ	50%
17	2.15.	Баян-Өлгий нисэх буудалд агаарын навигацийн үйлчилгээний ажиглалтын системийг шинээр суурилуулж,	Тоног төхөөрөмжий г хүлээн авсан эсэх Суурилуулал т хийсэн эсэх	I-IV улирал	ИНЕГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, сонгон шалгаруулалт хийгдсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд**: Тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. **II улиралд**:	Өлгий нисэх буудалд Польш улсын "Ansart" компанийн автомат хамааралтай ажиглалтын систем /ADS-B/-ийг шинээр суурилуулж, туршилт шалгалтын ажлыг хийсэн. Хүлээн авах комисс ажилласан. Хүлээн авах шатанд илэрсэн үл тохирлуудыг үйлдвэрлэгчээр	ҮҮГ	90%

		нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.	Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн эсэх			Суурилуулалт хийсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	залруулан тайланг авч, НААХЗА-руу ADS-B станцыг баталгаажуулах хүсэлт явуулсан. НААХЗА-ны байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн БД-1225/24 дугаар дүгнэлтээр ADS-B станцыг ашиглах боломжтой гэж дүгнэсэн. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2024 оны А/234 дугаартай тушаалын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглаж буй автоматжуулалтын системд холбон туршилтын ажлыг хийж байна. Тус туршилтын ажлын үр дүнгээс хамааран ашиглалт нэвтрүүлэх эсэх шийдвэр гарна.		
18	3.1.	/ИНЕГ 5.1/ "Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам"-ын хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 92.8 хувьтай биелсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд гишүүн байгууллагуудаас санал авч, нэгтгэн ИНЕГ-т хүргүүлсэн байна. **II улиралд:** Зөвлөлийн хурал зохион байгуулах бэлтгэлийг хангана. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 19хувиас доошгүй	"Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд бөгөөд Зөвлөлийн даргаар батлуулж, төлөвлөгөөг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/292 дугаар албан бичгээр гишүүн байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллахыг мэдэгдсэн. Мөн зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны бүрэлдэхүүнд ажиллах ажилтны нэрсийг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/138 дугаар албан бичгээр	ҮҮГ	100%

						хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэсэн байна.	гишүүн байгууллагуудаас авч НБДАА-ыг ИНЕГ-ын даргын 03 дугаар сарын 01-ний өдрийн А/141 дүгээр тушаалаар батлуулсан. Монгол Улс, АНУ-ын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд зарим асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлага гарсан тул 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ЗТХЯ-нд ИНАБЗ-ийн ээлжит бус хурал хуралдсан. ИНАБЗ-ийн ээлжит бус хурлын тогтоолыг ИНЕГ-аас 2024.03.22-ны өдрийн 01/551 дугаартай албан бичгээр ИНҮТ-д ирүүлсэн. ИНАБЗ-ийн ээлжит бус хурлын тогтоолын хэрэгжилт 75%, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024.11.20-ны өдрийн байдлаар 90%-ийн гүйцэтгэлтэй байна. ИНАБЗ-ын дагуу ИНАБЗ-ийн ээлжит хурлыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж, ЗТХЯ-ны ИНБЗГ-т 19 дүгээр хурлын шийдвэрийн хэрэгжилт, Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн хүргүүлж, хурлын тов тогтоолгохоор ИНЕГ-ын даргын 2024.07.04-ний өдрийн 01/1485 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Тов тогтоохыг хүлээж байна.		

19	3.2.	/ИНЕГ 5.2/ “Агаарын тээврийг хялбаршуулах журам”-ын хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.7 хувьтай биелсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд гишүүн байгууллагуудаас санал авч, нэгтгэн, ИНЕГ-т хүргүүлж батлуулсан байна. **II улиралд:** Зөвлөлийн хурал зохион байгуулах бэлтгэлийг хангасан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувиас доошгүй хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэсэн байна.	Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд бөгөөд Зөвлөлийн даргаар батлуулж, 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/320 дугаар албан бичгээр гишүүн байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллахыг мэдэгдсэн. Мөн зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэхтэй холбоотой НБДАА-д ажиллах ажилтны нэрсийг гишүүн байгууллагуудаас 2024 оны 02 дугаар сарын 07-ны 01/142 дугаар албан бичгээр авч, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/140 дүгээр тушаалаар баталсан. Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2024.11.20-ны өдрийн байдлаар 93.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, ЗТХЯ-ны ИНБЗГ-т 11 дүгээр хурлын шийдвэрийн хэрэгжилт, Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн хүргүүлж, хурлын тов тогтоолгохоор ИНЕГ-ын даргын 2024.07.04-ний өдрийн 01/1485 дугаартай албан бичиг хүргүүлсэн.	ҮҮГ	100%

							Тов тогтоохыг хүлээж байна.		
20	3.3.	/ИНЕГ 5.3/ Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журмыг батлуулах.	Журмыг батлуулсан эсэх	I улирал	Төслийг боловсруулж 2023.11.30-ны өдрийн 01/2197 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ыг батлуулсан байна.	"Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-д гишүүн байгууллагуудаас санал авч нэгтгэн ЗТХЯ-ны 2024.04.10-ны өдрийн 09/1531 дугаартай "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ын төслийг 2024.04.15-ны дотор ирүүлэх, "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн хурлыг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж, хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг нэгтгэн 2024.04.20-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичгийн дагуу ИНЕГ-ын даргын 2024.04.12-ны өдрийн 02/737 дугаартай албан бичгээр журмын төслийг, 2024.04.16-ны өдрийн 01/767 дугаартай албан бичгээр "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн 2024 оны 01 дүгээр хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төсөлд санал авахаар ЗТХЯ-нд тус тус хүргүүлсэн. Улмаар ЗТХЯ-аас уг төслийн боловсруулалтад анхаарч захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дахин боловсруулах чиглэл ирүүлсний дагуу төслийг дахин боловсруулж, нөлөөллийн шинжилгээ гишүүн байгууллагуудын санал Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын төслийн хамт 2024	ҮҮГ АБЧУГ	70%

							оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1189 дугаар албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. Холбогдох нэмэлт өөрчлөлт болон шаардлагатай мэдээллүүдийг цахимаар ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХЯ-аас журмын төслийг хянан үзээд холбогдох өөрчлөлтийг оруулан дахин ирүүлэхийг мэдэгдсэнтэй холбогдуулан төслийг шинэчлэн 2024.08.14-ний өдөр ИНЕГ-ын БХХ-т (munk-herdene.e@mcaa.gov.mn) цахим шуудангаар хүргүүлсэн. ИНЕГ-ын даргын 2024.09.04-ний өдрийн 01/1971 дугаартай албан бичгээр "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ын төсөл болон журмын төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг ЗТЯ-ны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 03/1561 дугаартай албан бичгээр "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулсан тул дахин санал авахаар албан бичгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын		

							өөрчлөлтийн яаманд хүргүүлсэн. ХБББОСЯ, БОУАӨЯ-наас тус тус саналгүй тул “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам”-ын төслийг ЗТЯ-ны удирдлагуудад танилцуулж байна.		
21	3.4.	/ИНЕГ 5.4/ “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам”-ын хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	"Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг болон зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/97 дугаар тушаалаар шинэчлэн батлалсан. Зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 85 хувь байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг батлуулсан байна. **II улиралд:** Зөвлөлийг хуралдуулж, шийдвэр гаргуулна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувиас доошгүй хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар байгуулсан “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл”-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн дарга С.Батболдоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр батлуулж, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 02/363 дугаар албан бичгээр гишүүн байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдсэн. Зөвлөлийн дэргэдэх НБДАА-ны бүрэлдэхүүн болон ажиллах журам ИНЕГ-ын даргын 2024.02.09-ний өдрийн А/55 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн батлагдаж, зөвлөлийн гишүүн байгууллагуудад 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 02/364 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	ҮҮГ АБЧУГ	90%

							"Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангагдсан боловч ЗТХЯ-ны зүгээс хурлын товийг эцэслэн тогтоогсогүй хүлээгдэж байгаа бөгөөд ИНҮТ-ийн зүгээс тус зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 багц, 10 арга хэмжээ тусгагдсан бөгөөд 2024.11.20-ны өдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 83%-тай байна.		
22	3.5.	/ИНЕГ 5.6/ Нисэх буудлын аэродромын хучилтын нөхцөлийг үнэлэх MNS Стандарт /2024-2025/ нэвтрүүлэх судалгаа хийж, төслийг боловсруулах.	Стандартыг боловсруулсан эсэх	I-III улирал	Олон улсын иргэний нисэхийн байгууллагын DOC 9137 Part 2-ыг судалж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Судалгаа хийсэн байна. **II улиралд:** Олон улсын иргэний нисэхийн байгууллагын DOC-ийн худалдан авалтыг хийсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Баталгаат орчуулгын газраар орчуулгыг хийлгэн, төслийг	Асфальтбетон ба цементбетоны хучилтын ашиглалтын байдлыг тоон утгаар үнэлэх олон улсын стандартуудыг судалж, АНУ-ын иргэний нисэхийн аэродромын "ASTM D5340 Standard Test Method for Airport Pavement Condition Index Surveys"- ын 2023 оны хувилбарыг боловсруулахаар шийдвэрлэсэн. АНУ-ын иргэний нисэхийн аэродромын "ASTM D5340 Standard Test Method for Airport Pavement Condition Index Surveys" стандартын 2023 оны хувилбарыг худалдан авч,	ҮҮГ	100%

						боловсруулж, ИНЕГ-т хүргүүлсэн байна.	баталгаат орчуулгын ажлыг гүйцэтгүүлсэн. Боловсруулалтын ажлыг хийж, 154 хуудас бүхий "Аэрсдрэмын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх" стандартын төслийг ИНҮТ-ийн даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09-1/1181 тоо-р албан бичгээр ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн хэлтэст хүргүүлсэн.		
23	4.1	/ИНЕГ 6.1/ "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах төсөл боловсруулах.	Төслийн санал боловсруулсан эсэх Олон улсын туршлага судалж, холбогдох төрийн бус байгууллагатай хамтарч ажилласан эсэх	I-III улирал	Урьдчилсан судалгааны ажлыг боловсруулж, Ерөнхийлөгчийн тамгын газарт танилцуулахаар хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах боломжийг эрэлхийлж, олон улсын сайн туршлага судалсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Нисэх буудалд Хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах төслийг боловсруулж, ИНЕГ-т хүргүүлсэн байна.	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулахтай холбсгдуулан олон улсын сайн туршлага судлах ажлын хүрээнд Итали-Сан Вито хотын Бриндизи, Малайз-Куала Лампур, АНЭУ-ын Дубай, Гана-Аккра, Панам дахь НҮБ-ын Хүмүүнлэгийн тусламжийн агуулахыг судалж, Монгол Улсад байгуулах боломжтой талбай болон хадгалах боломжтой бүтээгдэхүүнийг тэдорхой болгосон бөгөөд баримт бичгийн судалгааг хийж, тайлан дүгнэлт гаргасан. Мөн Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоол "Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай"-р "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын улсын тусгай хэрэгцээний газарт	БХТГ	100%

							Хүмүүнлэгийн тусламжийн агуулах барих газрыг оруулж батлуулсан. 2024 оны 07 дугаар сард ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн хэлтэстэй хамтран НҮБ-ийн Монгол Улс дахь суурин зохицуулагч Тапан Мишраг урьж, "Буянт-Ухаа" ОУНБ-ын үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх байршилтай танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах барилга, байгууламжийн төслийг боловсруулсан. Төслийг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ИНЕГ-ийн БХХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Энх-Амгаланд цахимаар (viber)-аар хүргүүлсэн. "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах барилга, байгууламжийн төслийг боловсруулан төслийг ИНЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/2643 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.		
24	4.2.	/ИНЕГ 6.2/ "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг сургалт, засварын төвийн	Төсөл боловсруулж, ИНЕГ-т танилцуулсан эсэх	I-III улирал	"Буянт-Ухаа" ОУНБ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 455 дугаар тогтоолын дагуу үйл	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Нисэх буудлыг сургалт, засварын төвийн зориулалтаар	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/152 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлагдсан бөгөөд тус ажлын хэсгээс "Буянт-Ухаа"	БХТГ ҮҮГ БУОУНБ	90%

		зориулалтаар ашиглах төсөл боловсруулж, ИНЕГ-т танилцуулах.	Санхүүжилт татах ажлыг зохион байгуулсан эсэх		ажиллагаа явуулж байна.	ашиглах төсөл боловсруулж, ИНЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төслийг хөрөнгө оруулагчдад хүргүүлж, санхүүжилт татах ажлыг зохион байгуулна.	олон улсын нисэх буудлыг сургалтын зориулалтаар ашиглах төсөл боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ИНЕГ-ын даргын 02/1030 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар тухайн төслийн цаашдын санхүү хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой хариу ирүүлээгүй байна. Мөн төслийг хөрөнгө оруулагчдад хүргүүлж, санхүүжилт татах ажлын хүрээнд "МИАТ" ТӨХК, "Аэромонголиа"ХХК, "Изинис Эйрвэйз"ХХК, "Монголиан Эйрвэйз"ХХК, "Хүннү Эйр"ХХК-д ИНҮТ ийн даргын 2024.11.19-ний өдрийн 09-1/1313 тоот албан бичгээр төсөлтэй танилцан цаашид хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах боломжтой эсэх талаар саналыг хүргүүлсэн.		
25	4.3.	/ИНЕГ 6.3/ "Жаргалант" амралтын газрыг өргөжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах төсөл боловсруулах.	Төсөл боловсруулж, ИНЕГ-т танилцуулсан эсэх Санхүүжилт татах ажлыг зохион байгуулсан эсэх	I-III улирал	Тус амралтын газрыг сувилал, сургалт, нислэгээс саатсан зорчигчдыг байрлуулах зочид буудал хэлбэрээр ашиглах төсөл боловсруулах шатандаа байна.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** "Жаргалант" сэргээн засах амралтын одоогийн нөхцөл байдал (барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, нөөц)-ын судалгааг боловсруулна.	"МИАТ"ТӨХК, "Аэромонголиа"ХХК, "Изинис Эйрвэйз"ХХК авиакомпанийн холбогдох албан тушаалтнууд болон БХТГ-ын удирдлага, мэргэжилтнүүд хамтран 2024 оны 05 дугаар сард энэ төсөл дээр хөрөнгө оруулалт хийж ажиллах санал болон, цаашид хийх ажлын талаар танилцуулга уулзалт зохион байгуулсан. "Жаргалант" сэргээн засах амралтын газрыг өргөжүүлэх,	БХТГ	100%

						Амралтын газрыг өргөжүүлж, сувилал, сургалт, нислэгээс саатсан зорчигчдыг байрлуулах хэлбэрээр ашиглах төсөл боловсруулж, төслийг ИНЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төслийг хөрөнгө оруулагчдад хүргүүлж, санхүүжилт татах ажлыг зохион байгуулсан байна.	үйл ажиллагааг сайжруулах бизнес төлөвлөгөөний төслийг 2024 оны 06 сарын 04 өдөр 09-1/673 дугаартай албан бичгээр ИНЕГ-ын даргад хүргүүлсэн. "Жаргалант" сэргээн засах амралтын газрыг өргөжүүлж, сувилал, сургалт, нислэгээс саатсан зорчигчдыг байрлуулах хэлбэрээр ашиглах төсөл боловсруулж, төслийг ИНЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1358 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Төслийг хөрөнгө оруулагчдад хүргүүлж, санхүүжилт татах ажлын хүрээнд "МИАТ" ТӨХК, "Аэромонголиа"ХХК, "Изинис Эйрвэйз"ХХК, "Монголиан Эйрвэйз"ХХК, "Хүннү Эйр"ХХК-д ИНҮТ ийн даргын 2024.11.19-ний 09-1/1313 тоот албан бичгээр тус төсөлтэй танилцан цаашид хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах, боломжтой эсэх талаар саналыг хүргүүлсэн. Энэхүү төслийн хөрөнгө оруулалтад нэмэлт өөрчлөлт хийж нийт 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн саналыг ашиглагч байгууллага болох "Жаргалант" сэргээн засах амралтын даргаар хянуулан БХТГ-ын даргаар батлуулж, ИНҮТ-ийн 2025 оны өөрийн орлогын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга		

							хэмжээний жагсаалтад санал тусгуулсан.		
26	4.4.	/ИНЕГ 6.4/ "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудалд орон нутгийн зарим нислэгийг шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд нислэг үйлдвэрлэлийн бэлэн байдлыг хангах.	Бэлтгэл хангагдсан эсэх	I-IV улирал	"Чингис хаан" олон улсын нисэх буудлаас орон нутгийн хуваарьт нислэгийг гүйцэтгэж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Орон нутгийн нислэгийг шилжүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлүүлсэн байна. **II улиралд:** "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудалд орон нутгийн зарим нислэгийг шилжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангасан байна. **Жилийн эцсийн байдлаар** **III-IV улиралд:** Орон нутгийн зарим нислэгийг "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал руу шилжүүлэхэд шаардлагатай	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын аэродромын бэлэн байдал, орон нутагт нислэг үйлдэж эхлэх үед үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бэлэн эсэх, нисэх буудлын зорчигч терминалын хүзүүвч, зорчигчийн бүртгэлийн цэг, ачаа тээшний туузан дамжуурга, мэдээллийн самбар, тусгай тоноглолтой цахилгаан шат зэрэгт газар дээр нь (check list) шалгах хуудсаар үзлэг шалгалт хийсэн. Нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж, нисэх буудлын дарга 2024.02.28-ны өдөр батлсан. 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Мөн Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх нар 2024 оны 03 дугаар сарын 1^-	ҮҮГ	100%

						бэлэн байдлыг хангасан байна.	ний өдөр уулзалт зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудалд орон нутгийн татаастай зарим нислэгийг шилжүүлэх талаар Япон Улсын ГХ-ны сайд Монгол Улсад айлчлах үеэр дахин хэлэлцэхээр хойшлуулсан.		
27	4.5.	/ИНЕГ 6.5/ Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөө боловсруулж, батлуулсан эсэх Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Хөтөлбөрийг хүчингүй болгосон.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх судалгаа хийж, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг түшиглэн хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, ИНЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Төлөвлөгөөнд тусгагдсан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 90-ээс доошгүй хувьд хүргэсэн байна.	Ерөнхий зориулалтыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ИНҮТ-ийн даргын 2024.04.11-ний өдрийн 09-1/367 дугаартай албан бичгийг ИНЕГ-т хүргүүлсэн. Тус төлөвлөгөөг батлуулахаар ИНЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/846 дугаартай албан бичгийг ЗТЯ-нд хүргүүлсэн. Мөн шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр цахимаар ЗТЯ-нд хүргүүлсэн. Ерөнхий зориулалтыг хөгжүүлэх төлөвлөгөөг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2024.08.20-ны өдөр баталсан. Тус батлагдсан төлөвлөгөөний дагуу “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө”-г боловсруулж, ИНҮТ-ийн даргаар 2024.09.06-ны өдөр батлуулж, ИНЕГ-т 2024.09.19-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. ИНҮТ-ийн даргын 2024 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр батлагдсан “Ерөнхий	ҮҮГ	50%

							зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэж байна.		
28	4.6.	/ИНЕГ 6.6/ Томоохон сум, суурин газруудад ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, вертодром барих ажилд мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлэх.	Зурвас, вертодром байгуулахад мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлсэн эсэх	I-IV улирал	2023 онд 5 цэгт вертодром байгуулсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** 5 хөөрч буух зурвас, вертодром байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** 5 хөөрч буух зурвас, вертодром байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.	2024.11.20-ны өдрийн байдлаар агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас 66 байршилд сонгож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.Үүнд: Онцгой, тусгай үүргийн нислэгт 61 удаа, Ерөнхий зориулалтын чиглэлээр 2 удаа, Авиа компанийн хүсэлтээр 3 удаа. ИНД - 157 "Аэродром байгуулах, өөрчлөх, нээх ба хаах"-ын хүрээнд нисэхийн судалгааг 3 байршилд, вертодром барих 4-н ажилд мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлж ажилласан. 1. Интернэйшнл медикал центер ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Интермэд эмнэлгийн барилгын дээврийн оройд нисдэг тэрэгний тавцант зогсоол байгуулах ажлын дүгнэлт зөвлөмжийг ИНҮТ-ийн 2024.03.05-ны өдрийн 9-1/186 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2. "Интернэйшнл сити центр" ХХК-аас ирүүлсэн 2024.01.05-ны өдрийн 02 дугаартай албан хүсэлтийн дагуу Сүхбаатар дүүргийн 1-р хороонд байрлах талбайд ажиллаж тайлан, дүгнэлтийг ИНЕГ-ын	ҮҮГ	100%

							2024.02.08-ны өдрийн 1/253 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 3. “Скай резорт” ХХК-аас ирүүлсэн 2024.01.10-ны өдрийн 01/008 дугаартай албан бичгийн хүрээнд ажлын хэсэг ажиллаж, тайлан болон зөвлөмжийг ИНЕГ-ын 2024.02.08-ны өдрийн 1/253 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 4. “Корпорейт хотел энд конвейшн центр” ХХК-ийн 17 давхар барилгын техникийн давхар дээр байгуулах өргөдсөн хелипортод мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажилласан. ИНД-157-ийн хүрээнд: 1. ҮҮГ-ын даргын 2024.06.05-ны өдрийн Архангай аймгийн нутаг дэвсгэрт нисэх буудал, аэродром байгуулах боломжийг судлах удирдамжийн дагуу 2024.07.08-07.11-ний өдрүүдэд Архангай аймагт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. 2. Их хаадын чулуу ХХК-ын хүсэлтээр Говь-Алтай болон Завхан аймаг 2024.04.05-10-ны өдрүүдэд АГСА-ны инженер судалгааны ажил хийж ажилласан. 3. “Хүннү эйр” ХХК-ийн 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А-24/290 дугаартай албан хүсэлтийн дагуу Өмнөговь аймгийн “Овоот” нисэх буудлын аэродромд		

							2024.09.13-16-ны өдрүүдийн хооронд газар дээр нь үзлэг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.		
29	4.7.	/ИНЕГ 6.12/ Баян-Өлгий аймаг дахь “Өлгий” нисэх буудлын зорчигч терминалын өргөтгөлийн барилгын ажилд техник, технологийн хяналт тавих.	Барилгын ажилд техник, технологийн хяналт тавьсан эсэх	III-IV улирал	Баян-Өлгий аймаг дахь Өлгий нисэх буудлын зорчигч терминалыг өргөтгөх ажлын хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг “Чандмань-Уушир” ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан. Сангийн яаманд ирүүлсэн гомдлын дагуу цуцалсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024.02.01 өдрийн А/26 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг Баян-Өлгий аймгийн засаг даргад шилжүүлсэн.	**Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Барилга угсралтын ажилд техник, технологийн хяналт тавьсан байна.	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024.02.01 өдрийн А/26 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг Баян-Өлгий аймгийн засаг даргад шилжүүлсэн. Уг ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн орон нутгийн өмчийн газраас Өлгий нисэх буудлын барилгын өргөтгөлийн ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг 2024.03.12-ны өдөр зарлаж, 04 дүгээр сарын 02-ны өдөр нээсэн. Тендерт 5 компани оролцсон. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Бапкер” ХХК-д 2024.04.11-ний өдөр гэрээ байгуулах эрх олгосон бөлөвч оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргасан. Сангийн яам хянаж тендерийг дахин үнэлэх зөвлөмж ирүүлсний дагуу үнэлгээ хийж, “Бапкер” ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон боловч Сангийн яамнаас уг ажлыг түдгэлзүүлж, эрх шилжүүлснийг буцаан татаж ЗТХЯ-нд ирүүлсэн. Одоогоор шийд гараагүй байна. ИНЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/359 дүгээр тушаалаар	УУГ ХОЗА	30%

							Барилгын ажилд техник технологийн хяналтыг хэрэгжүүлэх ажлыг хэсгийг томилсон. Гүйцэтгэгч компани шалгарсны дараа барилга угсралтын ажил гүйцэтгэж эхлэх цагаас холбогдох ажлын хэсэг эсхүл инженерийг томилж, барилга угсралтын ажилд хяналт тавина. Зам, тээврийн сайдын 2024.10.09-ний өдрийн А/214 дүгээр тушаалаар Баян-Өлгий аймгийн Өлгий суман дахь "Өлгий" нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг ИНЕГ-т шилжүүлсэн. Тушаалын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024.11.11-ний өдөр А/536 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна.		
